



ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/1038

Улаанбаатар хот

Түншлэлийн төслийн урьдчилсан
үнэлгээний тариф шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, 12.2.3, 12.2.7, 12.3, 19 дүгээр зүйл, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1455 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын дүрмийн 6.7.2, 6.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох хууль, журамд заасан түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ хийхэд Түншлэлийн төвөөс үзүүлэх судалгаа, шинжилгээ, арга зүйн дэмжлэг, санхүү, эдийн засгийн тооцоолол, хууль, бодлогын нийцлийн үнэлгээ болон бусад үйлчилгээний төлбөрийг тооцох зорилгоор “Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээний тариф”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан урьдчилсан үнэлгээний тарифын хэмжээг өөрчлөхгүйгээр, тухайн төслийн цар хүрээ, бэлтгэл хангагдсан байдал, шаардагдах судалгаа, шинжилгээний хэмжээ, ажил гүйцэтгэх бүрэлдэхүүн, зарцуулах хугацаа, нэмэлт мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад шууд зардлыг харгалзан төлбөрийн хэмжээг захирлын шийдвэрээр нэмэгдүүлж байхаар тогтоосугай.

3. Урьдчилсан үнэлгээний төлбөрийг хавсралтаар баталсан тариф, ажлын даалгавар, зардлын тооцоо, үйлчилгээний гэрээ, нэхэмжлэх, гүйцэтгэлийн акт, урьдчилсан үнэлгээний тайлан, дүгнэлт болон холбогдох санхүүгийн баримтад үндэслэн тооцож, нэхэмжлэн ажиллахыг Захиргаа, санхүүгийн газрын дарга /Д.Цоож/-д үүрэг болгосугай.

4. Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ хийхэд шаардлагатай нэмэлт дүн шинжилгээ, санхүү, эдийн засгийн тооцоолол, хууль зүйн болон бодлогын нийцлийн үнэлгээ, зах зээлийн мэдээлэл, бусад судалгаа, үйлчилгээний төлбөрийг тухайн байгууллагын төсөл санаачлагчтай байгуулах үйлчилгээний гэрээ, санхүүжилтийн баталгаа, нэхэмжлэх, гүйцэтгэлийн акт болон энэхүү тушаалаар баталсан тарифад үндэслэн тооцсугай.

5. Урьдчилсан үнэлгээний ажлын төлбөрийн хэмжээ нь хавсралтаар баталсан тарифын нийт дүнгээс хэтрэхгүй байх бөгөөд тухайн төсөлд нэмэлт зөвлөх үйлчилгээ, орон нутгийн томилолт, техникийн тусгай судалгаа, орчуулга, мэдээлэл худалдан авах зэрэг нэмэлт шууд зардал шаардагдах тохиолдолд уг зардлыг тусад

нь тооцож, захирлын шийдвэрээр баталгаажуулсны үндсэн дээр захиалагч талтай тохиролцон нэхэмжилнэ.

6. “Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээний тарифыг батлах тухай” 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/027 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, урьдчилсан үнэлгээний төлбөрийн тооцоо, нэхэмжлэх, орлого, зарцуулалт, тайлагналын хэрэгжилтийг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн газрын дарга /Д.Цоож/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв
ТӨААТҮГ-ын захирлын 2026 оны 07
дугаар сарын 24-ны өдрийн А/038 дугаар
тушаалын хавсралт



УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАРИФ

Нэг. Тарифын үндсэн дүн

Хийгдэх ажлууд		Үнэлгээ
Төслийн мэдээлэл, танилцуулга	Төслийн үндсэн мэдээлэл, танилцуулга	10,000,000
	Төслийн нийгмийн ач холбогдлын мэдээлэл	
	Төслийн эдийн засгийн бусад үр ашгийн талаарх мэдээлэл	
	Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны мэдээлэл	
	Төслийн улс, бүс нутаг, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж байгаа талаарх мэдээлэл	
	Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын талаарх мэдээлэл	
	Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл	
	Ажлын байрны мэдээлэл	
Санхүү, эдийн засгийн тооцоолол	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	5,000,000
	Санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо	
	Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ	
Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	Энэ хуульд заасан үнэлгээ, шинжилгээ, судалгаагаар төсөл нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйчилгээний салбарт түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой болох нь тодорхойлогдсон эсэх	5,000,000
	Хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн эсэх	
	Хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой төсөл байх, энэ хуульд заасан түншлэлийн төрөл, хэлбэрт нийцэж эсэх	
	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад үндэслэн дэд бүтцийг байгуулах, засвар үйчилгээ үзүүлэх, нийтэд зориулсан төрийн үйлчилгээг гүйцэтгүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, инновац, шинэ технологийг нэвтрүүлэх боломжтой эсэх	
	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эсэх	
	Тухайн төслийн хувьд хөрөнгө оруулагч болон санхүүжүүлэгч талууд төслийг хэрэгжүүлэх сонирхолтой болохыг зах зээлийн судалгаагаар тогтоосон, өрсөлдөөнт шалгаруулалт явуулах нь тодорхой болсон эсэх	
Нийт дүн		20,000,000



Хоёр. Төлбөрийн эцсийн хэмжээг тогтоох шийдвэрийн суурь мэдээлэл

№	Шалгуур	Тайлбар
1	Төслийн цар хүрээ	Төсөл хэрэгжих салбар, хэмжээ, өртөг, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг харгалзана.
2	Мэдээллийн бүрдэл	Ирүүлсэн баримт бичиг бүрэн эсэх, нэмэлт тодруулга шаардагдах эсэхийг үнэлнэ.
3	Шинжилгээний төвөгшил	Санхүү, эдийн засаг, хууль, бодлого, зах зээл, дэд бүтцийн судалгааны цар хүрээг харгалзана.
4	Ажиллах бүрэлдэхүүн, хугацаа	Оролцох ажилтан, мэргэжилтэн, шинжээчийн тоо, ажлын цаг, гүйцэтгэх хугацааг тооцно.
5	Нэмэлт зардал шууд	Томилолт, орчуулга, мэдээлэл худалдан авах, зөвлөх үйлчилгээ, техникийн тусгай тооцооллын зардлыг тусад нь тооцно.